

# АХМАД НАСТНЫ АСРАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ТОЙМ (БНХАУ-ЫН ЖИШЭЭН ДЭЭР)

*Bao Tonglaga*  
Доктор оюутан

*Монгол улсын их сургууль*  
*Шинжлэх ухааны сургууль*

*Я. Отгонбаяр*  
Доктор (Ph. D.), дэд профессор

*Монгол улсын их сургууль*  
*Шинжлэх ухааны сургууль*

*Хураангуй :* Энэхүү өгүүлэл нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдсанаас хойших ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцоо үүсэж хөгжсөн түүхэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн бөгөөд төлөвлөгөөт эдийн засгийн үеэс одоо болтол хэрэгжүүлсэн ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцоог тухайн нийгмийн байгууллын онцлог хийгээд насжилийн байдалд суурилан баримт бичгийн шинжилгээнд үндэслэж ахмад настны асрамжийн тогтолцооны давуу тал ба дутагдалтай талыг илрүүлсэн. Судалгааны үр дүнд, ахмад настны асрамжийн тогтолцоо нь зөвхөн асаргаанд тулгуурлаж байснаасаа аажмаар хөгжөөд ахмад настны асрамжийн үйлчилгээг бүх талаар дээшлүүлэх ба бүх ахмад настанд хүртээмжтэй байх асрамжийн үйлчилгээний тогтолцоогийн системийг бий болгох үйл явц эрчимтэй явагдаж байгааг харуулж байна. Өнөөгийн хүн амын насжилтийн байдал аажмаар гүнзгийрч, ахмад настны асрамжийн үйлчилгээний эрэлт нэмэгдэж, одоо байгаагаас илүү олон талт үйлчилгээний хэрэгцээ бий болж байна. Иймээс насжилтын онцлог, ахмад настны асрамжийн үйлчилгээний хэрэгцээнд чиглүүлэн оновчтой бодлогыг хэрэгжүүлбэл ахмад настанд үзүүлэх асрамжийн үйлчилгээ цогц системтэй болно.

*Түлхүүр үг:* Хүн амын насжилт; ахмад настны асрамжийн тогтолцоо идэвхтэй насжилт

## УДИРТГАЛ

Хүн амын насжилт нь хүн төрөлхтний эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүтээгдэхүүн бөгөөд 21-р зуунд дэлхийн олон улс орнуудад тулгарч буй нийтлэг бэрхшээл юм. ЮНЕСКО-аас нийтэлсэн "Дэлхийн хүн амын хэтийн төлөв 2022"-ын тоо баримтаас харвал, дэлхийн улс орнуудын ахмад настны хүн амын эзлэх хувийн жин нэмэгдэж байна. 1990 онд дэлхийн 65 ба түүнээс дээш насны хүн ам нийт хүн амын

6.2 орчим хувийг эзэлж байв. 2022 онд энэ хувь хэмжээ 10% хүртэл өссөн байна. 2050 онд 65 ба түүнээс дээш насны ахмад настануудын эзлэх хувь 16 хувьд хүрнэ гэж таамаглаж байна (United Nations, 2022) .

Хятад улс хөгжиж байгаа улс болсны хувьд мөн ч насжилтын асуудалд тулгамдаж байна. 2023 оны эцэст хятадын 60 ба түүнээс дээш насны хүн ам 297 саяд хүрч,

тус улсын нийт хүн амын 21.1%-ийг эзэлнэ; 65 ба түүнээс дээш насны хүн ам 220 саяд хүрч, улсын нийт хүн амын 15.4 хувийг эзэлнэ (Хятад статистикийн товчоо, 2024). Олон улсын холбогдол бөхий баримжаагаар, хятад ард улс нэгэнт дунд зэргийн насжилтын нийгэмд оров. Ийм их хурдацтай нэмэгдэж байгаа ахмад настны тоо нь хятадын эдийн засаг, нийгэм, улс төр, соёл зэрэг талын хөгжилтөд гүнзгий нөлөө үзүүлсэн байна. Ахмад настны асрамж, эм эмнэлэг, нийгмийн үйлчилгээ зэрэг талын хэрэгцээний даралт ч улмаас улам их болж байна.

Энэхүү өгүүлэл нь БНХАУ байгуулагдсанаас хойших нийгмийн байгууллын онцлог ба хүн амын насжилтын байдлыг үндэслэн ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцооны түүхэн өөрчлөлтийг гурван үе шат хувааж, ахмад настны асрамжийн асуудал, тухайн үед хэрэгжүүлсэн ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцооны хөгжлийн өнгөрсөн болон орчин үеийн тулгамдсан асуудлыг илрүүлсэн. Ач холбогдол нь Хятад улсын ахмад настны асрамжийн тогтолцооны үе шат бүрийн онцлогийг тайлбарлан авч үзсэнээр тухай үе бүрд байгаа онцлогийг нээн харуулах явдал юм. Энэ удаагийн өгүүлэлд Хятад улсын дотоод бодлогын өөрчлөлтийг цаг хугацааны хувьд харьцуулсан бөгөөд Монгол улс БНХАУ-ын ахмад настны асрамжийн

тогтолцоог дараагийн судалгааны ажилдаа тусган авч үзнэ.

### **Судлагдсан байдал, онол арга зүй**

Сүүлийн жилүүдэд Хятад улсын эрдэмтэн социологчдоос Хятадын хүн амын насжилтын байдал, насжилтын асуудлын тухай нэлээдгүй судалсан байна. Хятадын хүн амын насжилтад нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааны талаар судлаач Сүн И (Sun Yi) дундаж насралтыг уртасгаж, төрөлтийн хэм хэмжээ буурч байгаа нь Хятадын хүн амын насжилтын гол бөгөөд шууд шалтгаан гэж үзэж байна. Гэвч зарим эрдэмтэд эдгээр хоёр нөлөөлөгч хүчин зүйлийн талаар өөр үзэл бодолтой байдаг. Тухайлбал, Хо Жаннин (Hu Jianning) хүн амын насжилтыг нөлөөлөх гол хүчин зүйл бол төрөлтийн түвшин, харин төрөлтийн түвшинд нөлөөлөх үндсэн шалтгаан бол хүн амын нягтрал гэж үзсэн байна (Wangqingjuan, 2013). Хятадын ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцооны хөгжлийн түүхийн судалгааны талаар, Дү Пэн нар (Dupeng Ba busad, 2023) ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцоогийн хөгжлийг анхны үе (1982-1999), анхан шатны бүрэлдэх үе (2000-2005), гэр орон, хороолол, байгууллагад тулгуурласан үе (2006-2010), түргэн хөгжлийн үе (2011-2015), эрчимтэй хөгжлийн

үе (2016 оноос өнөөг хүртэл) гэсэн таван үе шатанд хуваасан. Фан фэнчүн нарын (Fanfengchun Ба бусад, 2024) үзлээр гэр бүлд тулгуурласан ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцоогийн хөгжлийг анхны хайгуулын үе (1993-1999), аажмаар үүсэх үе (2000-2012), эрчимтэй хөгжлийн үе (2013-2018) болон орон нутгийн чанарыг сайжруулах үе (2016 оноос өнөөг хүртэл) гэсэн дөрвөн үе шат хуваасан.

Түүнчлэн бусад орны социологичид олон эрдэмтэд хүн амын насжилттай холбоотой асуудлыг судалсан байдаг. Хүн ам зүйч Ronald Lee болон Andrew Mason (Ronald L.Mason A, 2014) нийгэм эдийн засгийн өсөлтийн тооцоцолол болон өрхийн амьжиргааны түвшинг харьцуулан тооцох загварыг хэрэглэж, Герман, Франц, Япон, Бразил, Хятад, Энэтхэг, Нигери зэрэг 40 улсын төрөлтийн хувь болон хүн амын насжилтын хоорондын хамраалыг судалсан байна. Тэд энэ судалгааны үр дүнд тухайн өрхийн эдийн засгийн байдал, орлого төрөлтөд нөлөөлдөг болохыг тодорхойлсон байна.

### **Онол ба судалгааны аргынталаар**

Энэ судалгаа нь түүхэн институционализмд суурилан, харьцуулсан түүхэн шинжилгээ болон баримт бичгийн шинжилгээний аргуудыг

хэрэглэж,Хятадын ахмад настны асрамжийн үйлчилгээний бодлогын хувьсалын механизм, мөн институцийн өөрчлөлтийн динамикийн үндсэн логикийг судалж байна.Түүхэн институционализм нь дунд түвшний институцийн өөрчлөлтийн үйл явцыг (Paul Pierson, 2004)төвлөрүүлдэг бөгөөд институцийн хувьсалд бүтцийн орчин, түүхэн цаг хугацаа, үйл ажиллагааны оролцогчдын харилцан үйлчлэл, ялангуяа өмнөх институцууд дараагийн бодлогыг хэрхэн хэлбэржүүлдэг талаар онцгой анхаарал тавьдаг (Kathleen Thelen, 2004). "Бүтэц-түүх" гэсэн хоёр хэмжээст шинжилгээний үндсэн дээр суурилсан энэ арга нь Хятадын ахмад настны асрамжийн үйлчилгээний бодлогын системийн үүсэл, хувирлыг тайлбарлахад тохиромжтой хэрэгсэл болдог.

Хятадын ахмад настны асрамжийн үйлчилгээний хуулийн үндсэн загвар нь "гэр бүлээс хариуцах – улсаас хариуцах – нийгмийн байгууламжаас харилцан хариуцах" хэмээх хувьсалын замналаар хөгжсөн бөгөөд"Ахмад настны эрхийн хамгаалах тухай хууль" (1996 онд батлагдсан, 2018 онд шинэчлэгдсэн)-иар дөрийн бодлогын голлогч болгож (БНХАУ-ын төрийн явдлын хороо, 2013), нийгмийн хамтын ажиллагаа (БНХАУ - ын буяны хууль, 2023) зах зээлийн оролцоотой хууль ёсны хүрээг бүрдүүлсэн. Мөн "Анагаах ухаан-асрамжийг уялдуулах"

бодлог нь институционалчлах ажлыг хөгжүүлэн дэмжиж байна (БНХАУ-ын төрийн явдлын хороо, 2022).

### **Ахмад настны асрамжийн үйлчилгээний төрийн бодлого ба эрх зүйн орчин**

БНХАУ байгуулагдсанаас хойш ахмад настны асрамжийн үйлчилгээний хөгжлийг ахмадын асрамжийн эхлэлийн үе шат, ахмадын асрамжийн суурь институцийг бий болгох үе шат, идэвхтэй насжилтыг дэмжих үе шат гэсэн гурван үе шат хуваасан. Энэ хугацаанд ахмад настны асрамжийн үйлчилгээний тогтолцоо нь эдийн засгийн хөгжилтэй уялдуулан насжилтад дасан зохицох идэвхгүй хэлбэрээс, улмаар насжилтад идэвхтэй хариу үйлдэл үзүүлэх төрийн бие даасан бодлогод шилжсэн.

- Ахмадын асрамжийн тогтолцооны эхлэлийн үе шат (1949-1978 он)

Тус шатанд Хятад улс нийгмийн хувьсгалаар дамжуулан эрх тэгш нийгмийн суурийг байгуулж, амьдралын үндсэн хэрэгцээг хүртээмжтэй хангах, хуваарилах бодлогыг хэрэгжүүлж, ахмад настны асрамжийн үйлчилгээний механизмыг **төвлөрсөн** төлөвлөгөөт эдийн засгийн бодлогод тусган оруулсан.

Тухайн үед хотод бүх нийтээр ажиллах, хөдөлмөрлөх гэсэн уриатай байсан учраас ахмад настны асрамжийн үйлчилгээний

хэрэгцээг тусгай байгууллагаас илүү ба гэр бүлд нь хариуцуулж, онцгой тохиолдолд ганц бие, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг цөөн тооны ахмад настанг асрамжийн газар байгууламжид амьдрах боломж олгож байв. Тухайлбал, хот хөдөөд 1951 онд батлагдан мөрдөж эхэлсэн БНХАУ-ын Хөдөлмөрийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйл төмөр зам, усан тээвэр, шуудан, харилцаа холбооны салбарын тэтгэвэр тэтгэмжийг тогтоож, цэргийн хүрээлэн болон улсын сургууль зэрэг төрийн байгууллага, аж ахуйн нэгж, Бусад байгууллагуудад тэтгэвэр тогтоолгох журам нэмж оруулсан байна (БНХАУ-ын тогтоомжийн мэдээллийн сан, 1953). Энэ үе нь бүх нийтийн бүтээн байгуулалтын үе байсан.

Хөдөө тосгонд, ардын нэгдлийн дүрэм нь ерөнхийдөө ядуу эмзэг бүлэг, гэр бүлд хүнсэн амуу ба амьдралын үндсэн баталгаа хангахаар гол суурь болгож, ахмад настны асрамжийн үйлчилгээний механизмд голдуу дараах хэдэн талыг багтаана.

Нэгд, Хятадын уламжлалт ёс зүйд тулгуурлан төрөл төрөгсөд, найз нөхөд нь өндөр настанд асрамжийн үйлчилгээ үзүүлдэг.

Хоёрт, 1950 онд нийгмийн халамжийн таван шалгуурын тогтолцоог бий болгосноор амьдралдаа түшин тулах хүнгүй ганц бие ахмад настан, буурай, өнчин, бэлэвсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст идэх, өмсөх,

түлш, оршуулах, боловсрол хүртээх (хүүхэд ба багачууд) -г багтаасан. Гуравт, асрамжийн газар болон бусад байгууллагууд ганцаардсан ахмад настнуудад эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хэлбэрүүд бий болсон.

Өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулахад хятадын хүн амын насжилтын түвшин, ахмад настны тусламж дэмжлэг нь төлөвлөгөөт эдийн засгийн хугацаанд харьцангуй бага, ахмад настны асрамжийн үйлчилгээний эрэлт нь харьцангуй цөөн, гэр бүлийн гишүүдийн дундаж тоо 4.5 орчим хүнтэй, гэр бүлийн хүрээнд ахмад настнаа асрах чиг үүрэг харьцангуй бүрэн байсан Хве Лин (Guolin, 2019).

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай учраас тухайн үед ч гэсэн хүмүүсийг ажлын байранд шууд томилон ажиллуулдаг байснаас хотруу шилжих хөдөлгөөн бага байсан. Үүнтэй холбоотой гэрийн хүмүүс бие биедээ туслан дэмжих тогтолцоо сайн байсан гэж үзэж болно. Нөгөө талаас өрхийн бүртгэлийн систем хатуу шаардлагатай тул хүн бүр хотруу шилжих боломжгүй байсан.

Иймээс Хятадын тус үе шатны хүн амын шилжилт хөдөлгөөн бага байгаа болохоор гэр бүлийн гишүүд ахмад настны асрамжийн үйлчлээд илүү оролцоотой байсан нь энэ үеийн онцлог байжээ.

Ер нь энэ үеийн ахмад настны асрамжийн үйлчилгээний

механизмыг социалист тогтолцооны үүднээс нийт хүн амыг нийтийн өмч ба хамтын өмчийн төлөө гэсэн уриан дор хөдөлмөрлүүлж нийгмийн суурь эдийн засгийг хөгжүүлэх гол зорилгын дор бусад зараим үйл ажиллагааг хойш тавьж байсны нэг нь ахмад настны асрамжийн үйлчилгээ байсан Хве Лин (Guolin, 2019).

- Ахмадын асрамжийн суурь институцийг бий болгох(1979-2000 он)

Шинэчлэл нээлт ба социалист зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бий болсноор хотын боблон хөдөөгийн хооронд ажиллах хүчний шилжилт нэмэгдэж, хүн амын дунд насжилт уртасч, залуу гэр бүлүүд хүүхэд төрүүлэх байдал эрс багассанаас үүдэн ахмад настны нийгмийн хамгааллын хэрэгцээ нэн тэргүүнд тавигдаж, насжилтын асуудал нь нийгмийн асуудал болж бүрэлджээ. Учир нь 1976 онд Хятадын засгийн газраас өрх бүр нэг хүүхэд төрүүлэх тухай бодлого гарган хээргжүүлжээ.

1982 онд, Хятад улс насжилтын асуудлаарх дэлхийн чуулганы Хятадын хороог байгуулж, мөн тус онд Хятадын насжилтын асуудлын хороо гэж нэрлэв. Энэ нь Хятад улс ахмад настны нийгмийн халамжийн тухай төрийн бодлого нь анх удаа тусгай институт байгуулагдаж байгаа явдал юм. 1989 онд, Хятад улс анх удаа "Засгийн ордны ажлын илтгэл" дээ хүн амын насжилт нь Хятад ард

улсын нийгмийн чухал асуудал болж байна, энэ улсын бүх хэлтэс албад бүгд ахмад настны тухай асуудалд анхаарал хандуулах ёстой гэж онцлон тэмдэглэв Дү Пэн (Dupeng Ба бусад, 2023). 1990 оноос Хятад улс хүн амын түргэн насжилт ба гэр бүлийн ахмад настанд асрамж хангах чадвар аажмаар суларч байгаа бодит байдалд чиглэсэн стратегийн бодлого боловсруулж, хууль тогтоомж гаргах ажлыг эхлүүлсэн. 1994 оны сүүлчээр тус улс "Хятадын насжилтын ажлын долоон жилийн хөгжлийн хөтөлбөр (1994-2000) " -ыг боловсруулж, насжилтын асуудлыг улсын эдийн засаг болон нийгмийн хөгжлийн төлөвлөгөөнд оруулж, Ахмад настны нийгмийн халамжийн төрийн бодлогын анхдагч дунд урт хугацааны төлөвлөгөөг баталсан байна (Wuyushao, 2023). Энэ байдал нь нэг талаас дэлхий нийтийн жишиг нөгөө талаас нийгмийн хөгжлийн үр шимийг бүх бүлэг хүртэх ёстой гэсэн үзэл баримтлал хэрэгжих нөхцөл хангагдсан гэсэн үг.

Ахмад настан нь нийгмийн эрх тэгш, идэвхтэй гишүүний хувьд баталгаатай орлоготой байж, эрүүл мэнд, нийгмийн бусад шаардлагатай үйлчилгээг чанартай, хүртээмжтэй авах, гэр бүл, нийгэм, хамт олны дунд аз жаргалтай, сэтгэл хангалуун амьдрах эрхтэй. (Я.Отгонбаяр ба бусад, 2024) Хууль тогтоомжийн хувьд, 1996 онд Хятад

улс түүхэндээ анхдагч "БНХАУ-ын настайчуудын эрх ашгийг батлах хууль" -ыг тогтоожээ. Энэ хуульд, ахмад настны асаргаа сувилгаа гэр бүлээс голчлон хамаарахгүй гэдгийг тодорхой зааж өгөхийн зэрэгцээ, асрамжийн газар, ахмад настны эрүүл мэндийг дэмжих төв зэргийг нийгэм буюу хувь хүнээс эрхлэн ажиллуулахыг уриалж, өрхийн асаргаа, нийгмийн халамжийг нэг алхам урагш нь хөгжүүлэх ёстой гэсэн санааг хуулийн хүрээнд тодотгож өгсөн.

2000 онд, Хятад улсын коммунист намын төв хороо, Төрийн явдлын хороогоос ахмад настны асрамжийн үйлчилгээний хөтөлбөрийн баримт бичиг болох "ахмад настанд үзүүлэх үйлчилгээг эрчимжүүлэх тухай шийдвэр" -ийг гаргаж, насжилтын талаар баримтлах үзэл санаа, зарчим, зорилгыг тодорхойлж, насжилтын үйлсийг хөгжүүлэх ажлыг түргэтгэх чанартай арга хэмжээ авах шаардлага тавьсан.

Энэ хугацаанд Хятадын Засгийн газар хүн амын насжилтын тухай тодорхой ойлголттой болж, ахмад настны бодлогын тогтолцоог бий болгохыг чухалчилж, насжсан нийгэмд орсны дараах ахмад настны асрамжийн үйлчилгээг цаашид хөгжүүлэхэд түлхэц болсон.

- Идэвхтэй насжилтыг дэмжих үе шат (2001 оноос өнөөг хүртэл)

2000, 2001 онд хятадын 65 ба түүнээс дээш насны өндөр настны нийт хүмүүн амд эзлэх хувь

тус тус **6.96%**, **7.10%** байв. (Хятад улсын статистикийн жилийн ном 2001-2002). Энэ нь хятад улс **2000-** оноос эрчимтэй насжсан нийгэмд орсныг харуулж байна. Гэвч Хятадын ахмад настны асрамжийн үйлчилгээний макро систем, ахмад настны асрамжийн үйлчилгээний тодорхой механизм, хүний хүчний нөөц зэрэг талаар бүрэн бэлтгэгдээгүй байна.

Хүн амын насжилт хурдтай явагдаж байгааг харгалзан, Хятадын засгийн ордноос хүн амын насжилтын асуудлыг улсын таван жилийн төлөвлөгөөнд оруулж эхэлжээ. **2001** онд "Хятадын насжилтын талаарх аравдугаар таван жилийн төлөвлөө (**2001-2005** он)"-нд, ахмад настны гэр бүлийн асрамжийг үргэлжлүүлэн дэмжиж, хувь хүмүүсийн тэтгэврийн бэлтгэлд нь дэмжлэг үзүүлж, засгийн ордон, нийгэм, гэр бүл болон хувь хүмүүсийг уялдуулсан тэтгэврийн тогтолцоог сайжруулах замыг тууштай баримталж, асрамжийн газрын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж дурдсан.

**2013** онд "Ахмад настны асрамжийн үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого"-ыг нийтлэж, "**90-7-3**" ахмад настны асрамжийн үйлчилгээний бүтцийг анх удаа дурдан гаргав. Тухайлбал **90** гэдэг нь ахмад настанг гэр бүлээрээ асран хамгаалж, **7** нь хороо, аймаг, сум, нэгжээс асрамж хүртэж, **3** нь тусгай ахмад настны

асрамжийн байгууламжаас асрамж хүртэнэ гэж тусгаж өгсөн (Yuanxin, 2024). Үүний зэрэгцээ, нийгмийн капиталын хүртээмжийн стандартыг тодорхой болгож, ашгийн бус чанартай асрамжийн газрын үнийг чөлөөтэй болгоно. Энэхүү бодлого нь ахмад настны асрамжийн үйлчилгээг нийгэмшүүлэх, зах зээлжүүлэх суурийг тавьж, ахмад настны асрамжийн үйлчилгээний салбарт нийгмийн бусад байгууллага орохыг боломжийг нэмэгдүүлж, ахмад настны асрамжийн үйлчилгээний олон талт оролцогчийн бүтцийг дэмжсэн.

**2021** оны "БНХАУ-ын ардын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх **14-р** таван жилийн төлөвлөгөө, **2035** он хүртэлх хэтийн зорилт"-д анх удаа өрхөд суурилсан, асрамжийн үйлчилгээ, гэрээр үзүүлэх ахмад настны асрамжийн үйлчилгээ байгуулах санал дэвшүүлж, ахмадын асрамжийн газар, нийгмийн халамжийн үндсэн үйлчилгээг сайжруулах ажлыг эхлүүлсэн. **2021** онд "Эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр (**2021-2025**)", "Ахмад настанд яаралтай, чанартай тусламж үзүүлэх гурван жилийн төлөвлөгөө"-ийг дараалан гаргасан.

Эдгээр тогтолцоог хэрэгжүүлснээр ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн олон талт үйлчилгээний чанарыг дээшлүүлэн, ахмад настны олон талт хэрэгцээг

хангана. Энэхүү шатанд, ахмад настны асрамжийн үйлчилгээний бодлого нь "үндсэн хэрэгцээнд суурилсан асрамжийн хэлбэр" -ээс "олон талт хэрэгцээг хангах хэлбэр"- д шилжиж, бодлогын чиглэл нь эдийн засгийн хангамжийн арга барилын шинэчлэлээс үйлчилгээний чанарыг сайжруулахад шилжсэн.

### **Ахмад настныг асрамжийн үйлчилгээтэй холбоотой орчин үеийн зарим тулгамдсан асуудал**

Хятадын хүн амын насжилтын явц хурдасч, нийгмийн халамжийн нөөцийн хуваарилалтын үр ашиг, эрүүл мэндийн үйлчилгээний системийн тогтвортой байдал, гэр бүлийн үеийн бүтцийн өөрчлөлт, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийн хэв маяг зэрэгт системчилсэн нөлөө үзүүлсэн.

**Нэгд,** Хятадын хүн амын насжилт гүнзгийрэхийг дагалдан гэр бүлийн ахмад настныг асрах чадвар суларч байна. Уламжлалт гэр бүлийн ахмад настны халамж нь гэр бүлийн гишүүдийн харилцан халамж дээр суурилдаг. Үе хоорондох холбоо харьцангуй ойр бөгөөд эцэг эхийн "хүүхдийн хүмүүжил" болон үр хүүхдүүдийн "ахмад настны асаргаа" хоёрын хооронд сайн эргэлттэй байдаг. Гэвч 1980-аад оноос хойш хүмүүсийн дунд хүүхэд төрүүлэх байдал буурч, Хятадад гэр бүлийн тоо цөөрч байлаа. Өмнөх жилүүдийн хүн амын тооллогын

мэдээгээр, Хятад улсын нэг өрхийн хүн амын дундаж тоо 1953 онд 4.33 байснаас 2020 онд 2.62 болж буурсан. Тэрчлэн гэр бүлийн бүтцийн өөрчлөлтөөс болж, гэр бүлийн ахмад настаныг асрах чадвар дагалдан буурч байна (Хятад статистикийн товчоо, 2024).

**Хоёрт,** Хятадын хүн амын насжилт гүнзгийрэхийг дагалдан тэтгэврийн зардал он дараалан нэмэгдэж байна. 2024 оны эцэст Хятадын 60 ба түүнээс дээш насны хүмүүсийн тоо 300 саяас давж, нийт хүн амын 22 орчим хувийг эзэлсэн. 65 ба түүнээс дээш насны хүмүүсийн тоо 240 саяд хүрч, нийт хүн амын 16.5 орчим хувийг эзэлж (Хятад статистикийн товчоо, 2024), насжилтын эрчимтэй гүнзгийрэх хандлага үргэлжилсээр байна. Суурь тэтгэврийн даатгалд бараг 1.1 тэрбум хүн хамрагдаж байгаа ч хүн амын бүтцийн өөрчлөлтөөс болж тэтгэвэр авах иргэдийн тоо жил дараалан нэмэгдсээр байна. 2019-2024 онд ахмад настны асрамжийн үйлчилгээ, ахмад настны халамжийн улсын төсвийн зардал 560 тэрбум юаниас давж, жилийн дундаж өсөлт 11%-иар нэмэгдэх болсон (БНХАУ-ын Төрийн зөвлөлийн мэдээллийн алба, 2025). Үүнээс болж, Хятадын эдийн засгийн дарамт улам гүнзгийрсэн.

**Гуравт,** Хятадын хүн амын насжилт гүнзгийрэхийг дагалдан эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэж, эмнэлгийн

даатгалын чадавхи хүндрэлтэй болсон. Тав дахь удаагийн Хятадын хот хөдөөгийн өндөр настны амьдралын нөхцөл байдлын судалгаагаар Хятадад одоо 35 сая орчимын хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан байгаа бөгөөд өндөр настны өвчлөлийн түвшин нийт хүн амын дунджаас 4 дахин их байна. Гэтэл эмчилгээ эрүүл мэндийн үйлчилгээний нөөц, хэмжээ хүрэлцэхгүй, хүртээмж муу зэрэг асуудал нилээд тулгамдаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ насжилтын хэрэгцээг хангахад дутагдалтай байна.

**Дөрөвт**, хөдөө орон нутагт насжилт, тэтгэврийн дарамт харьцангуй хүнд байна. Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжлийн түвшин хотаас доогуур, харин хүн амын насжилтын түвшин хот газрынхаас өндөр байна. Хятадын долоо дахь удаагийн хүн амын тооллогын тоо баримтаас үзвэл, Хятадын хөдөө тосгонд 121 сая өндөр настан байгаа бөгөөд хотын насжилтын түвшин 15.8%, хөдөөгийн насжилтын түвшин 23.8% байгаа нь хотын насжилтаас 8.0 нэгжээр илүү байна (Хятад статистикийн товчоо, 2024). Гэтэл өндөр чанартай ахмад настны асрамжийн нөөц, үйлчилгээ нь хотод илүү төвлөрдөг. Хөдөө орон нутагт ахмад настны асрамжийн газар бага мөртөө, туслах үйлчилгээ хангалтгүй, хамгаалалт сул байна.

## ДҮГНЭЛТ

- Төлөвлөгөөт эдийн засгийн хугацаанд, Хятад улсын ахмад настны хүн амын тоо бага болохоор хот хөдөөгийн тэтгэврийн тогтолцоо нь ахмад настны үндсэн асрамжийн үйлчилгээг хангасан. Гэтэл хот хөдөөгийн асрамжийн үйлчилгээний зөрүү их, хотын байгууллагын асрамжийн тогтолцоо нь эдийн засгийн дарамтыг хүндрүүлсэн бөгөөд 1970 оноос төрөлтийн хувь огцом буурснаас, гэр бүлд ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл гарч эхэлсэн байна.
- 1979-2000 онд Хятадын хүн амын насжилт хурдасч, Засгийн газраас ахмад настны асрамжийн тогтолцоо систем байгуулахыг эхлэн чухалчилж, холбогдол бүхий төрийн бодлого ба хуулийг нийтэлсэн. хотод нийгмийн даатгал, иргэдийн цалин хөлсийг уялдуулсан тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгож, хөдөө орон нутагт тэтгэврийн даатгалын туршилтын төслийг хэрэгжүүлжээ. Энэ үеийн гол онцлог гэвэл олон шатат чанартай асрамжийн тогтолцооны суурийг бий болгосон. Дутагдалтай тал гэвэл тогтолцооны хамрах хүрээ ханагалтгүй, хөдөө тосгоны асрамжийн үйлчилгээнд төдийлөн нөлөөлж

- чадаагүй байна.
- 2001 оноос өнөөг хүртэлх үед Хятадын хүн амын насжилт үргэлжлэн гүнзгийрч, ахмад настны асрамжийн тогтолцооны систем тодорхой түвшинд сайжирсан. Ялангуяа хот хөдөөг нэгтгэсэн суурь асрамжийн үйлчилгээний тогтолцоог бий болгож, олон шатат буюу хувь хүн, бусад байгууллагын оролцоог хангасан асрамжийн үйлчилгээний тогтолцоог хөгжүүлсэн. Гэсэн хэдий ч өнөөдөр ч гэсэн ахмад настны асрамжийн үйлчилгээний хүртээмж чанар жигд бус бөгөөд хот хөдөөгийн зөрөө илэрхий байна.

### НОМ ЗҮЙ

1. Dupeng Ба бусад. (2023). *The changing path, driving mechanism and future transformation of China's elderly care service policy*. *Journal of Zhongzhou*
2. Fanfengchun Ба бусад. (2024). *Changes in China's Community Home Care Service Policy: Process, Logic and Prospect - Based on Historical Institutionalism Analysis*. *Social Security Research*, 1-11
3. Guolin. (2019.7). *China's Elderly Care Services Over 70 Years (1949-2019): Evolution, Policy Evaluation, and Future Directions*. *Chinese Social Security Review*
4. Kathleen Thelen. (2004). *How Institutions Evolve: The Political Economy of Skills in Germany, Britain, the United States, and Japan*. Cambridge University Press.
5. Paul Pierson. (2004). *Politics in Time: History, Institutions, and Social Analysis*. Princeton University Press

6. Ronald L. Mason A. (2014). *Is low fertility really a problem? Population aging, dependency, and Consumption*. *Science*
7. WANG KAI. (2024). *хятад улсын одоохчилалтд хандсан насжилын батлагын төрийн бодлогын хөгжилт. нийгмийн батлагийн шүүмж*, 143-155
8. Wangqingjuan. (2013). *Китайн хүн амын хөгшрөлтийн тухай уран зохиолын тойм*. *Xijiang Monthly*, 329-330
9. Wuyushao. (2023). *Хятадын ахмад настны үйлсийг хөгжүүлэх 40 жилийн эргэцүүлэл ба илчлэлт*
10. Yuanxin. (2024.12). *Тэтгэврийн үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгож, "9073" хэв маягийг шийдвэрлэх. дэлхийн цаг сонин*
11. Я.Отгонбаяр ба бусад. (2024.10.8). *Ахмад настны асрамжийн үйлчилгээний харьцуулсан судалгаа: БНСУ, МОНГОЛ улсын жишээгээр*. *Mongolian Journal of Population*, 109-122
12. United Nations. (2022.6). *World Population Prospects*. [https : //population.un.org/wpp/](https://population.un.org/wpp/)
13. БНХАУ-ын буяны хууль. (2023.5). *БНХАУ - ын иргэний төрийн хэлтэс*. <https://www.mca.gov.cn/n2623/n2687/n2696/n2744/c1662004999979998115/content.html>
14. БНХАУ-ын тогтоомжийн мэдээллийн сан. (1953.1.2)
15. БНХАУ-ын Хөдөлмөрийн даатгалын журам. 2025.4.8, БНХАУ-ын тогтоомжийн мэдээллийн сан
16. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн мэдээллийн алба. (2025.1.15). *Төрийн зөвлөлийн Хэвлэл мэдээллийн албаны хэвлэлийн бага хурал дээр тэтгэврийн үйлчилгээний шинэчлэл, хөгжлийг гүнзгийрүүлэхтэй холбоотой арга хэмжээг танилцуулав*. 17 [https://www.gov.cn/zhengce/202501/content\\_6998124.htm](https://www.gov.cn/zhengce/202501/content_6998124.htm)
18. БНХАУ-ын төрийн явдлын хороо. (2022.2.11). *15-дүгээр таван жилийн төлөвжүүлээгийн хугацааны БНХАУ-ын насжилын үйлсийн хөгжилтийн*

төлөвжүүлэг.БНХАУ-ы засгийн газрын сүлжээ

19. БНХАУ-ын төрийн явдлын хороо. (2013.9.6). Ахмад настны асрамжийн салбарыг хөгжүүлэх талаарх Төрийн зөвлөлийн хэлэлцүүлэг.Хятадын засгийн газрын сүлжээ

20. Хятад улсын статистикийн жилийн ном 2001-2002 . Хятад статистикийн товчоо.

<https://www.stats.gov.cn/sj/ndsj/>  
Хятад статистикийн товчоо. (2024). Хятад статистикийн товчоо. 2025.4.15

21. <https://www.stats.gov.cn/sj/ndsj/>